



КАНАД УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Иргэний эрх зүйн маргаан¹)

АЛЬ ХЭДИЙН ОНЛАЙНААР БАЙРШУУЛСАН БҮТЭЭЛИЙГ СТРИЙМИНГ ХИЙХЭД ХОЁР БИШ ЗӨВХӨН НЭГ РОЯЛТИ ТӨЛӨХӨД Л ХАНГАЛТТАЙ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуй ашигласан шийдвэр нь гадаадын хяналтын шатны шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 39418

Шүүхийн шийдвэрийн огноо: 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдөр

Шийдвэрийн төлөв байдал: Холбооны Давж Заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээн шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Канадын Зохиогчийн эрхийн тухай хуулийн дагуу бүтээл туурвисан хүн тус бүтээлийн "зохиогчийн эрх"-ийг эзэмшдэг бөгөөд бүтээлийг хуулбарлах, ашиглах эрхтэй цорын ганц хүн юм. Хэрэв гуравдагч этгээд бүтээлийг хуулбарлах эсвэл ашиглахыг хүсвэл зохиогчийн эрх эзэмшигчээс зөвшөөрөл авах ёстой бөгөөд ихэвчлэн роялти² (royalty) гэж нэрлэгддэг төлбөр төлөх шаардлагатай.

Зохиогчийн эрх эзэмшигч нь радио гэх мэт харилцаа холбооны хэрэгслээр бүтээлээ олон нийтэд хүргэх эрхтэй цорын ганц хүн юм. Дээрх эрхэд бүтээлийг интернэтэд байршуулах замаар онлайнаар "ашиглах боломжтой болгох" гэх ойлголт багтана гэдгийг тодотгохоор 2012 онд Зохиогчийн эрхийн тухай хуульд шинэ хэсэг нэмэгдсэн байна. Жишээ нь дууг татаж авснаар дууны шинэ хуулбар үүсдэг тул хуулбарлалтын роялти төлөх ёстой гэсэн үг юм.

Канадын "Зохиогчийн эрхийн зөвлөл" (The Copyright Board of Canada) нь зарим онлайн үйлчилгээнд төлөх роялтигийн хэмжээг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг холбооны захиргааны байгууллага юм. Канадын "Хөгжмийн зохиолч, Зохиогч ба Хөгжмийн Нийтлэлчдийн Нийгэмлэг" (Society of Composers, Authors and Music Publishers of Canada) зэрэг олон газраас Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэ хэсгийг хэрхэн тайлбарлаж хэрэглэх талаар тус Зөвлөлд ханджээ. Канадын Хөгжмийн зохиолч, Зохиогч ба Хөгжмийн Нийтлэлчдийн Нийгэмлэг бол хөгжмийн

¹ Шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.scc-csc.ca/case-dossier/cb/2022/39418-eng.aspx>

² Роялти (Royalty) гэдэг нь зохиолч, хөгжимчдийн бүтээлийг зарах эсвэл тоглох үед төлдөг төлбөр юм. Тэд ихэвчлэн эдгээр борлуулалт эсхүл гүйцэтгэлээс ашгийн тодорхой хувийг авдаг гэж Коллинсын толь бичигт тайлбарласан байна. <https://www.collinsdictionary.com/dictionary/english/royalty> Сүүлд үзсэн: 2023.07.03.

зохиолч, хөгжмийн нийтлэлч³ (music publisher), дүрслэх урлагийн чиглэлийн уран бүтээлчдэд зориулж роялтиг цуглуулж, хуваарилж өгдөг байгууллага юм. Тус Нийгэмлэг нь бүтээлийг онлайнаар “ашиглах боломжтой болгох” нь дараа нь тухайн бүтээлийг татаж авах, дамжуулахад төлдөг роялтигаас тусдаа роялти төлөх ёстой гэж үзсэн байна. Дэлгэрүүлбэл, онлайн хөгжмийн үйлчилгээ нь хувь хэрэглэгчдэд онлайнаар сонсох боломжтой байдлаар дугаа интернэтэд байршуулахдаа роялти төлөх ёстой гэсэн үг юм. Харин дууг татаж авах эсвэл стрийминг⁴ хийх үед өөр роялти төлнө гэж Нийгэмлэгийн зүгээс үзсэн ба уг асуудлын хувьд Зохиогчийн эрхийн зөвлөл нь Нийгэмлэгтэй санал нэг байжээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Холбооны Давж заалдах шатны шүүхээс** “Зохиогчийн эрхийн зөвлөл”-ийн шийдвэрийг хүчингүй болгосон. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэ хэсэг нь хэрэглэгчид бүтээлийг татаж авах, стрийминг хийх үед төлөх ёстой роялти төлбөрөөс гадна бүтээл байршуулахад шинэ, тусдаа роялти үүсгэхгүй гэж үзжээ. Канадын Хөгжмийн зохиолч, Зохиогч ба Хөгжмийн Нийтлэлчдийн Нийгэмлэгээс Давж заалдах шатны шүүхийн магадлалд гомдол гаргасан байна.
2. **Хяналтын шатны шүүхээс** Канадын Хөгжмийн зохиолч, Зохиогч ба Хөгжмийн Нийтлэлчдийн Нийгэмлэгийн гомдлыг хэрэгсэхгүй болгож, Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж, Зохиогчийн эрхийн тухай хууль нь онлайнаар бүтээлийг үзэхэд нэг удаа нэг роялти төлбөр төлөхийг шаарддаг гэж үзэж, дараах байдлаар тайлбарлажээ.
3. “Зохиогчийн эрхийн зөвлөл”-ийн Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэ хэсгийг тайлбарласан байдал нь хуулийн текст, зорилго, хэрхэн үйлчилж байгаа болон зохиогчийн эрхэд холбогдох Дээд шүүхийн өмнөх шийдвэрүүдтэй зөрчилдсөн болохыг Хяналтын шатны шүүхээс тогтоожээ. “Зохиогчийн эрхийн зөвлөл”-ийн тайлбарын дагуу хэрэв хэрэглэгчид радио гэх мэт бусад арга хэрэгслийг ашиглахын оронд бүтээлийг интернэт дээр сонсох тохиолдолд илүү төлбөр төлөх шаардлагатай болно. Энэ нь **хууль онлайн бүтээл болон офлайн бүтээлд адил хандах ёстой гэсэн технологийн төвийг сахих зарчмыг (principle of technological neutrality) зөрчиж байгаа бөгөөд хэрэглэгч юу хүлээж авах нь чухал болохоос хэрхэн хүлээж авах нь чухал биш** гэж Хяналтын шатны шүүх тайлбарлав.

³ Хөгжмийн нийтлэлч (Music publisher) нь дууны үг зохиогч эсвэл хөгжмийн зохиолчдын нэрийн өмнөөс тэдний бүтээлээс олсон бүх роялтиг цуглуулж, төлөх чиг үүргийг хэрэгжүүлдэг гэж тайлбарласан байна. <https://dittomusic.com/en/blog/music-publishing-explained-for-musicians/> Сүүлд үзсэн: 2023.07.06.

⁴ Стрийминг (Streaming) гэдэг нь интернэтээс өгөгдлийг татаж авах шаардлагагүйгээр хэрэглэгчийн компьютер эсвэл утасны дэлгэц рүү шууд дамжуулах арга гэж Коллинсын толь бичигт (Collins dictionary) тайлбарласан байна. <https://www.collinsdictionary.com/dictionary/english/streaming> Сүүлд үзсэн: 2023.07.03.

4. Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэ хэсэг нь тухайн бүтээлийг онлайнаар байршуулах эсвэл онлайнаар ашиглах боломжтой болгох үед тэрхүү бүтээл нь "холбогдсон" ("communicated") гэдгийг зүгээр л тодотгосон гэж Хяналтын шатны шүүх үзжээ. Энэ нь аль хэдийн роялти төлүүлдэг. Хэрэв хувь хүн ижил бүтээлийг стрийминг хийж байгаа бол нэмэлт роялти төлөх шаардлагагүй. Стрийминг гэдэг нь уг бүтээлийг онлайнаар ашиглах боломжтой болох үеэс эхэлсэн "нэг тасралтгүй үйл явцын" нэг хэсэг юм. Ийм учраас аль хэдийн онлайнаар байршуулсан бүтээлийг стрийминг хийхэд хоёр биш зөвхөн нэг роялти төлөхөд л хангалттай. Бүтээлийг татаж авах гэдэг нь арай өөр ойлголт ба энэ нь уг бүтээлийг олон нийтэд цахилгаан холбоогоор хүргэх эрх биш, бүтээлийг хуулбарлах эрх гэсэн тусдаа эрхийн асуудлыг хамаардаг гэж тайлбарлажээ.

Орчуулсан: Э.Номинсогоо
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Иргэний эрх зүйн судлаач